



**ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ,
МЬЯНМАРЫН ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН ЯАМ
ХООРОНДЫН
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Гадаад хэргийн яам (цаашид "Тал", хамтад нь "Талууд" гэх),

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм болон Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенцид дурдсан улсуудын бүрэн эрхт тэгш байдлын зарчмыг удирдлага болгож,

Монгол Улс болон Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улс хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны цаашдын хөгжилд Талууд хоорондын хамтын ажиллагааны ач холбогдлыг анхааралдаа авч,

Олон улсын, бүс нутгийн болон хоёр талын харилцан сонирхсон асуудлаар тогтмол зөвлөлдөж, санал солилцох хоёр талын механизм байгуулах шаардлага байгааг харгалзаж,

Ийм төрлийн механизм байгуулах нь хоёр талын хамтын ажиллагааны түвшинг дээшлүүлэх, хүрээг өргөжүүлэх, харилцан ойлголцол, итгэлцлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэж,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 дүгээр зүйл

Зорилго

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн зорилго нь дипломат шугамаар харилцан тохиролцсон асуудлаар хоёр талын яриа хэлэлцээг бэхжүүлэх болон хамтарсан хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг дэмжих болно.

2 дугаар зүйл

Түвшин, агуулга

Талууд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол болон хоёр талын хамтын ажиллагааны бүхий л салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэн



дэмжиж, харилцан сонирхсон олон улсын бусад асуудлыг хэлэлцэх дэд сайд нарын түвшинд зөвлөлдөх уулзалтыг бий болгож, тогтмол зохион байгуулна.

3 дугаар зүйл

Хамтын ажиллагааны хүрээ

1. Зөвлөлдөх уулзалтын хүрээнд Талууд тулгамдаж буй нийтлэг ашиг сонирхол буюу хоёр талын болон олон улсын асуудлаар санал солилцоно.

2. Талууд дипломатын сургалт зохион байгуулах болон сургалтын хөтөлбөр солилцох замаар хоёр улсын дипломатчдыг бэлтгэх болон сургах хамтын ажиллагааны тогтолцоог бий болгоно.

3. Талууд өөрсдийн бүрэн эрхийнхээ хүрээнд өөр өөр түвшинд болон бүхий л салбарт хоёр улсын хоорондын харилцааг цаашид хөгжүүлэх шинэ хэлбэрийг эрэлхийлж ажиллана.

4 дүгээр зүйл

Зөвлөлдөх уулзалтын газар, давтамж

1. Талууд Улаанбаатар, Нейпидо хотноо ээлжлэн, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Асамблейн болон АСЕАН-ны Бүсийн чуулга (АРФ)-ийн хүрээнд зохион байгуулагдах зөвлөлдөх уулзалтын хөтөлбөр, газар, товыг харилцан тохиролцоно.

2. Тал бүр зөвлөлдөх уулзалтад оролцохтой холбогдох өөрсдийн байр болон хоёр талын замын зардлыг хариуцна.

3. Зөвлөлдөх уулзалт Улаанбаатар, эсхүл Нейпидо хотноо зохион байгуулагдах тохиолдолд хүлээн авагч Тал тухай бүр харилцан тохиролцсоны дагуу нөгөө Талын төлөөлөгчдийн тэргүүн болон харилцан тохиролцсон зарим дагалдан явах төлөөлөгчдийн байр, хоол, орон нутгийн тээвэр зэрэг дотоодын зардлыг хариуцна.

4. Зөвлөлдөх уулзалт олон талт уулзалтын хүрээнд зохион байгуулагдах тохиолдолд тус уулзалтыг зохион байгуулахтай холбогдуулан гарах зардал, уулзалтын танхимын зардлаар хязгаарлагдахгүйгээр, ээлжлэн Тал бүр хариуцна.

5. Нийтлэг сонирхлын нэн тэргүүний асуудлыг хэлэлцэх зорилгоор Ажлын хэсгийн болон эрдэмтэн судлаачдын уулзалтыг зохион байгуулж болно.



5 дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбоотой зөрүүг Талууд зөвлөлдөх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл

Статус

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь олон улсын эрх зүйн дагуу эрх, үүрэг үүсгэхгүй бөгөөд заавал дагаж мөрдөх баримт бичиг биш болно. Хоёр улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу тухайн улсын эдлэх эрх, хүлээх үүрэгт энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.

7 дугаар зүйл

Төгсгөлийн заалт

1. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн таван (5) жилийн хугацаанд хүчинтэй байна.
2. Энэ хугацаа дуусгавар болсны дараагаас аль нэг Тал энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг цуцлах тухай зургаан сарын өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдэх хүртэл дараа дараагийн таван (5) жилд сунгагдана.
3. Талууд дипломат шугамаар бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр хэдийд ч энэхүү харилцан ойлголцлын санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
4. Аль нэг тал энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг цуцлах хүсэлтэй байгаа өдрөөс 6 сарын өмнө хэдийд ч бичгээр нөгөө талдаа мэдэгдсэнээр энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг цуцлаж болно.



Нейпидо хотноо 2014 оны 8-дугаар сарын 9-ны өдөр монгол, мьянмар, англи хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахтай холбоотой зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ

Чулууны БАЯРМӨНХ
Гадаад харилцааны яамны Ази,
номхон далайн орнуудын газрын
захирал

МЬЯНМАРЫН ХОЛБООНЫ БҮГД
НАЙРАМДАХ УЛСЫН ГАДААД
ХЭРГИЙН ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ

У Сан ЛВИН
Гадаад хэргийн яамны
Улс төрийн газрын гүйцэтгэх
захирал